НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 17 өдөр Дугаар 97 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс барилга хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2015 оны 02-07-81/805 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Нийслэлийн Хүрээ амаржих газрын баланст бүртгэлтэй нийт 42,000,000 /дөчин хоёр сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2 зоорины барилгыг акталж, хавсралт ёсоор нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Ж.БАТБАЯСГАЛАН

11101002 88

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугаар сарын
17-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилгын нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Зоорь-1	62	м.кв	25	21,000,000	21,000,000	-
2	Зоорь-2	62	м.кв	25	21,000,000	21,000,000	-
Нийт дүн					**42,000,000**	42,000,000	-